



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 188

Улаанбаатар хот

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж”-
төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн
үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой нөхцөл
бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Захирал Г.Гансүхтэй байгуулсан 2024 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын Захирал Г.Гансүхтэй Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, 2024 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн Захирал Г.Гансүхэд хавсралтад заасны дагуу урамшуулал олгосугай.

4. Захирал Г.Гансүхэд хавсралтын дагуу олгох урамшууллыг холбогдох эх үүсвэрээс гаргахыг “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий нягтлан бодогч Б.Дэлгэрдалайд зөвшөөрсүгэй.


5. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 428 дугаар тогтоолын хавсралт

"ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ" ТӨРИЙН ӨМЧИТҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛД 2024 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

/төгрөгөөр/

д/д	Хуулийн этгээдийн нэр	Захирлын нэр	Цэвэр ашиг	Цэвэр ашгийн дүнгээс хасаж тооцох валютын ханшийн өөрчлөлтөөс олсон ашиг алдагдал	Урамшуулал тооцох цэвэр ашиг	Олгох урамшууллын хэмжээ
1	"Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ	Г.Гансүх	2,138,903,967.79	-	2,138,903,967.79	25,427,780.79 (Хорин таван сая дөрвөн зуун хорин долоон мянга долоон зуун наян төгрөг далан есөн мөнгө)